

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 8 дугаар сарын 26-ны өдөр

№22

Дархан-Уул аймаг

Аймгийн Засаг даргын Шуурхай хурал 2019 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 08 цаг 00 минутад аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд эхлэв. Хуралдааныг аймгийн Засаг даргын орлогч Т.Ганболд удирдаж, хуралд нийт 18 удирдах албан тушаалтнууд оролцохоос 16 оролцож хуралдааны ирц 88,8 хувьтай байв. Гишүүдийн ирцийн бүртгэлийг хавсаргав.

### **ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

1. Хэлтэс, алба, сумдын дарга нарын өнгөрсөн 7 хоногийн ажлын тайлан, холбогдох шуурхай мэдээ, мэдээллийг танилцуулах, өмнөх шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх мэдээ, тайланг танилцуулах.

Хуралд оролцсон хэлтэс, албад, сумдын дарга нар өнгөрсөн 7 хоногт хийсэн ажлын тайланг танилцуулав.

### **ҮҮРЭГ, ДААЛГАВАР:**

Архивын улсын үзлэг дараа 7 хоногт ирнэ. Бэлтгэлийг сайн хангая. Аймгийн Засаг даргын Тамгын газрыг зайлшгүй шалгана. Л.Алтанчимэг дарга төлөвлөгөөнийхөө дагуу бэлдүүлээрэй. Мэргэжлийн бус хүмүүс ажиллуулсан гэсэн яриа гарсан. Шаардлагатай бол мэргэжлийн хүмүүс авч ажиллуулах. /ХЭЗХ/

Хонгорын Хар бэлчирт баригдах фермерийн газар дээр гомдол ирж шүүх хуралд орсон. Давж заалдсан гэж яриад байсан. Даваагүй гэж шүүхийн хүнээс мэдээлэл авлаа. Үнэн шийдвэрийг нь олоод шуурхай бидэнд үзүүлээч. Шийдвэр гаргамаар байна. /ХЭЗХ/

Дархан сумын 5 дугаар багийн 35,36 дугаар брак байшингийн иргэдтэй уулзсан. 9 дүгээр сарын 10-ны өдрөөс өмнө буюу халаалт дулаан ирэхээс өмнө нүүхээр чиглэл өгсөн. Дулаан, усны төлбөртэй хүмүүсийг асуудлаа шийдэхийг хэлсэн. Дундаа төлөөллийн байгууллагатай болох талаар багийн даргад нь үүрэг өгсөн. Хяналт тавьж гүйцэтгэлийг нь хангуулаарай. /ХЭЗХ, ХОХБТХ/

Хичээлийн шинэ жилийн нээлтийг анхааръя. Б.Азжаргал даргын хэлснээр нээлтийг хэзээ хийхээ тодорхой болгоод сургууль, цэцэрлэгүүддээ чиглэл өгье. /НБХ/

Сургууль, цэцэрлэгүүдийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг анхааръя. Хавар хичээл сургууль амрахаас өмнө асуудлуудаа жагсаагаад өгөөрэй гэсэн. Маш цөөхөн газар тодорхой санал өгсөн. Бусад нь таг чиг байж байгаад 9 сарын 1-ний өдөр болохоор баахан төсөв барьж орж ирэх юм аа. Бараг 300-аад сая төгрөгний асуудал тавьсан. Захирал, эрхлэгч нар хариуцлагагүй байна шүү. Өөрсдийнхөө боломжоороо өвөлжилтийн бэлтгэл хангах үүрэг чиглэл өгөөрэй. /НБХ/

Багийн төвийн байруудаа анхааръя. УИХ-ын гишүүд бухимдалтай байгаа. Хөрөнгө оруулалт олж ирээд байхад ажлаа хийхгүй байна гээд байгаа. Хоёр удаа зарлагдаад оролцогч ирээгүй гэсэн. Санал ирээгүй дээр нь санал өгч болно оо. Шийдвэр гараагүй байгаа газрууд байгаа бол шуурхайлаарай. /Дархан сум/

Мал бүхий иргэдэд Хонгор суманд газар олгоё гээд шийдвэр гарсан. 776 га газар олгосноос урагшаа 100-аад га газар олгосон. Азжаргал дарга тэр газрын асуудлыг судлаарай.

Хурал 09 цаг 15 минутад дуусав.

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

П.БАЯРСАЙХАН

НЭГТГЭСЭН:ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН:

Ц.БОЛОРТУУЛ